

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 16-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

Д/Д	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
	<p>Үүрэг, даалгавар-НЭГ: 2023 онд нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь чанартай гүйцэтгэх, санхүүжилтийн үйл ажиллагааг төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох журамд нийцүүлэн ил тод шуурхай, зохион байгуулж хэрэгжүүлэх, хүнд суртал гаргахгүй байх.</p>			
	<p>Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан дүүргийн төсвийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах ажлыг хуулийн хугацаанд зохион байгуулж, явцын гүйцэтгэл, санхүүжилтэд хяналт тавин ажиллаж байна. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд шинээр хэрэгжүүлэх 23 төсөл арга хэмжээ, он дамжин хэрэгжих 48 төсөл арга хэмжээ, Орон нутгийн сангийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх 24 төсөл арга хэмжээ, он дамжин хэрэгжих 11 төсөл арга хэмжээ тус тус батлагдсаныг хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөж байна.</p>			
	<p>Үүрэг, даалгавар-ХОЁР: 2023 онд нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь чанартай гүйцэтгэх, санхүүжилтийн үйл ажиллагааг төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох журамд нийцүүлэн ил тод шуурхай, зохион байгуулж хэрэгжүүлэх, хүнд суртал гаргахгүй байх.</p>			
	<p>Чингэлтэй дүүргийн төсвийн хөрөнгөөр 2022 онд ашиглалтад орсон 16 дугаар хорооны “Тэгш Өлзий” Өрхийн эрүүл мэндийн төвийн барилгыг дүүргийн өмчид бүртгэн авах саналыг дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 3/3268 дугаар албан бичгээр Нийслэлийн Өмчийн харилцааны газарт хүргүүлсэн.</p>			
	<p>Үүрэг, даалгавар-ГУРАВ: Нийслэл хотод зөвшөөрөлгүй баригдсан барилга, байгууламж болон голын эрэг дагуу олгосон газрын зөвшөөрөл, барилга, байгууламжийн жагсаалтыг гаргах, цаашид цэгцлэх ажлуудын талаарх санал боловсруулж танилцуулах.</p>			
	<p>Дүүргийн нутаг дэвсгэрт голын урсац эрэг дагуу /50 метр доторх/ газрын эзэмших эрхийн зөвшөөрөл олгогдсон 614 нэгж талбар газрын зөвшөөрөл бүхий барилга байгууламжийн</p>		<p>Голын эрэг дагуу олгосон газрын</p>	

	судалгааг гаргаж, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны Газар зохион байгуулалт, төлөвлөлтийн хэлтсийн дотоод сүлжээнд байршуулж ажилласан.		зөвшөөрлийн /50 метр доторх/ судалгааны дагуу цаашид хийгдэх ажлын санал боловсруулж танилцуулга бэлтгэх	
Үүрэг, даалгавар-ДӨРӨВ: Зуслангийн бүсийн орц гарц, хашаа, хайс, нүхэн жорлон зэргийг цэгцлэх ажлуудын бэлтгэл ажлыг сайтар хангах.				
	Дүүргийн нутаг дэвсгэрийн зуслангийн бүсийн орц гарц, хашаа, хайсны судалгааг шинэчлэн гаргасан. Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны Газар зохион байгуулалт, төлөвлөлтийн хэлтсийн дотоод сүлжээнд 11 нэгж талбарын судалгааг байршуулсан. Мөн дүүргийн 24 дүгээр хорооны Шадивлангийн 1-67 тоотод оршин суугч Д.Дорждэнзэнгийн хашааны хаалгыг таглан буусан иргэн Ж.Хоролсүрэнг нүүлгэн асуудлыг бүрэн шийдвэрлэж ажиллалаа.		Судалгааны дагуу төлөвлөгөө гаргах	
Үүрэг, даалгавар-ТАВ: Байгаль орчны сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилгоор саарал усны шинэ технологийг нэвтрүүлэх, /Hybrid/ автомашины батарей, моторын тос, тосол, аюултай хог хаягдлын талаар цаашид авч хэрэгжүүлэх санал боловсруулж танилцуулах				
	Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хороо, Бага тойруу Г-4 тоотод байрлах “Эн Эс Ти Эн” ХХК-ийн “Эко” автомашин угаалгын газар нь усны нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглах зорилгоор АНУ-ын “Coleman hanna car wash systems” компанийн хаягдал усаа цэвэршүүлэн дахин ашиглах автомат төхөөрөмжийг 2014 онд суурилуулан “Саарал ус ашиглах технологи”-ийг 2015 оноос эхлэн үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна. Нийслэлийн Байгаль орчны газар тус компанитай хамтран авто машин угаалгын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжид “Саарал ус дахин ашиглах технологи”-ийг нэвтрүүлэх үзүүлэх сургалтыг 2023 оны 2 дугаар улиралд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Дүүргийн нутаг дэвсгэрт авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжид аюултай хог хаягдлын бохирдлын түвшин стандартаас давсан тохиолдолд хяналтын улсын байцаагчид хандаж, экологи эдийн засгийн үнэлгээ хийлгэх арга хэмжээг зохион байгуулж, зөрчлийг арилгуулах талаар хяналт хийх ажлыг 2023 оны 2 дугаар улиралд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Дүүргийн хэмжээнд аюултай хог хаягдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагуудын судалгааг эцэслэн гаргаж, цаашид хог хаягдлыг тусгай зориулалтын компаниар тээвэрлүүлэх ажлыг 2023 оны 02 дугаар улирлаас эхлэн хэрэгжүүлэн ажиллана.			

Үүрэг, даалгавар-ЗУРГАА: Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний бэлтгэл ажлыг шуурхай зохион байгуулах хүрээнд газар олголтын асуудлыг шийдвэрлэн, газрын гэрчилгээ олгох, гэрээ байгуулах, нөхөх олговортойгоор газар чөлөөлөх, чөлөөлсөн газрыг нийтийн эдэлбэр газарт бүртгэж авах зэрэг бэлтгэл ажлыг сайтар хангах.			
	Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Газрын зөрчил арилгах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/388 дугаар захирамжаар дүүргийн нутаг дэвсгэрт 138 объектыг чөлөөлсөн бөгөөд нийтийн эдэлбэрт 10 байршлын газрыг авах саналыг хүргүүлсэн. Дүүргийн Засаг даргын 2023 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нийт 1500 байршилд газар эзэмших эрх олгохоор тусгагдсан ба уг асуудлыг 2023 онд дүүргийн Засаг даргын захирамжаар шийдвэрлэх юм.		Дүүргийн 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллана.
Үүрэг, даалгавар-ДОЛОО: Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын чиг үүргийг салбарын байгууллагуудад шилжүүлсэнтэй холбогдуулж нийслэлийн иргэдийн эрүүл, аюулгүй орчныг хангах төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах ажлыг шуурхай зохион байгуулах.			
	Хүнсний үйлдвэр, худалдаа, үйлчилгээ, хадгалалт, түгээлтийн үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт, эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг хангаж ажиллаж байгаа эсэхэд урьдчилан сэргийлэх хяналт хийж, халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг 2023 онд дүүргийн Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс хийж хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.		
Үүрэг, даалгавар-НАЙМ: Сайжруулсан шахмал түлшний зохистой, аюулгүй хэрэглээ, иргэдийг угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалахтай холбоотой зөвлөмж, мэдээллийг иргэд олон нийтэд хүргэх, сурталчлах ажлыг тогтмол зохион байгуулах.			
	Сайжруулсан шахмал түлшний зохистой, аюулгүй хэрэглээ, иргэдийг угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалахтай холбоотой зөвлөмж, мэдээллийг дүүргийн “Чингэлтэй дүүрэг/Chingeltei District” болон хороодын цахим хаягаар тогтмол хүргүүлэн ажиллаж байна. Мөн 2022-2023 оны галлагааны улиралтай холбогдуулан угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх чиглэлээр 29,000 гаруй зөвлөмж бүхий гарын авлагыг иргэд, олон нийтэд тараасан. Сурагчдын ээлжийн амралттай холбогдуулан дүүргийн 7-24 дүгээр хорооны Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газар, Онцгой байдлын хэлтэс, “Таван толгой түлш” ХХК-тай хамтран “Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх” чиглэлээр сургалт зохион байгуулж, сургалтад Ерөнхий боловсролын 7 сургуулийн 592 сурагчийг хамруулсан.		
Үүрэг, даалгавар-ЕС: 2023 онд нийслэлээс улсад төвлөрүүлэх орлого, дүүргүүдээс нийслэлд төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө өмнөх оноос нэмэгдсэн дүнтэй байгаа учраас дүүргүүд оны эхнээс төсвийн орлогын бүрдүүлэлтийг эрчимжүүлэх, татварын орлогын бааз суурийг өргөжүүлж ажиллах.			
	Улс, нийслэл, дүүргийн төсвийн татварын орлогын 2023 оны төлөвлөгөө эцэслэн батлагдаагүй тул 2022 оны 01 дүгээр сарын төлөвлөгөөний гүйцэтгэлтэй харьцуулж орлогын гүйцэтгэл, биелэлтийг харьцуулан оруулж ажиллаж байна.		

<p>1.Улсын төсөв 2022.01 сар: 2,771,104.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 4,605,812.0 мянган төгрөг төвлөрүүлж, 166.2% гүйцэтгэлтэй байсан бол 2023 оны 01 сарын 22-ны өдрийн байдлаар улсын төсөвт 2,768,132.3 мянган төгрөг төвлөрүүлсэн.</p> <p>2.Нийслэлийн төсөвт 2022.01 сар: 1,136,271.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 1,800,018.0 мянган төгрөг төвлөрүүлж, 166.2% гүйцэтгэлтэй байсан бол 2023 оны 01 сарын 22-ны өдрийн байдлаар улсын төсөвт 591,289.1 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.</p> <p>3.Дүүргийн төсөв 2022.01 сар: 8,364,081.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 4,101,729.0 мянган төгрөг төвлөрүүлж, 49% гүйцэтгэлтэй байсан бол 2023 оны 01 сарын 22-ны өдрийн байдлаар улсын төсөвт 7,348,186.5 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.</p> <p>Төсвийн татвар орлого төвлөрүүлэх ажлын хүрээнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Тайлан ирүүлээгүй 345 татвар төлөгчийн тайлангийн ирцийг дуудаж, 2. 796,0 сая төгрөгийн өрд Нэхэмжлэх хүргүүлсэн. <p>Мөн 380 татвар төлөгчийн 4,5 тэрбумын өрийг утсаар дуудаж боломж авч ажилласан ба дүүргийн төсвийн орлого 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар 8,364,081.3 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Цаашид төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг жигд ханган, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх ажлуудыг эрчимжүүлэн ажиллаж байна.</p>			
<p>Үүрэг, даалгавар-АРАВ: 2023 онд гэр хорооллын доторх ногоон байгууламж бүхий цэцэрлэгжсэн талбайн хэмжээг нэмэгдүүлэхэд анхаарах, аж ахуйн нэгж иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, мод сөөгийн нэр төрлөөр нь тооллого бүртгэлийн суурь мэдээллийг санг бий болгох, ногоон байгууламж нэмэгдүүлсэн талбайг байнгын арчилгаатай байлгахад анхаарч ажиллах.</p>			
<p>Дүүргийн ААНБ-д ногоон байгууламжийг зайлшгүй бий болгох талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа ба төлөвлөгөөт хяналт, шалгалтад хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжид ногоон байгууламжийг бий болгох, оролцоог нэмэгдүүлэх талаар тогтмол мэдэгдэл хүргэж ажилласан. Дүүргийн 7-24 дүгээр хороодын айл өрхүүд 2022 онд хашаандаа нийт 6 төрлийн 1737 мод тарьж ургуулснаас: чацаргана 1015, үхрийн нүд 510, алим 12, гүзээлзгэнэ 34, бөөрөлзгөнө 76 бусад төрлийн 90 мод тус тус тарьсан. Дүүргийн хэмжээнд мод сөөгийн нэр төрлөөр нь тооллого бүртгэлийн суурь мэдээллийн санг II, III улиралд шинэчлэхээр төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.</p>			
<p>Үүрэг, даалгавар- АРВАН НЭГ: 2023 онд хийгдэх явган хүний зам, дугуйн зам, ногоон байгууламжуудыг хийгдэх техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах бэлтгэл ажлыг сайтар хангаж ажиллах.</p>			
<p>Дүүргийн 2023 онд хийгдэх явган зам, дугуйн замын ажлын төлөвлөгөөг баталж, 4-6 дугаар хороодын нийт 7 байршилд 8097 м2 явган зам, 7-19 дүгээр хороодод 4500 м2 дугуйн зам тус тус хийхээр төлөвлөгөн ажиллаж байна. Дүүргийн гэр хорооллын нутаг дэвсгэрт нутаг дэвсгэрт хүнс, худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ногоон байгууламжгүй иргэн, аж ахуйн нэгжүүдийн судалгааг тодотгон төлөвлөгөөт хяналт зохион байгуулж, ногоон байгууламжийг зайлшгүй бий болгох</p>			

	талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ногоон байгууламж бий болгох, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр төлөвлөн ажиллаж байна.			
--	---	--	--	--

ЗАСАГ ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

П.БАЯНБААТАР

ТАНИЛЦСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Л.БАЯРМАА

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА

Н. НАРАНЗУЛ

НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Т.ТҮВШИНЖАРГАЛ